



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ерөнхий дүгнэлт: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН
ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД: ОРА-2022/22-13-ШТА-ТД



Эрдэнэт хот
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Ц.Нармандах

Утас: 70353888 Цахим хаяг: naemandakhts@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оргилмөрөн

Утас: 70350757 Цахим хаяг:

Аудитор Б.Бямбатогтох, Б.Азжаргал, О.Хэрлэнзаяа
Т.Болормаа, Г.Даваасүрэн

Утас: 70350757 Цахим хаяг:



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн

гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.07.01 № 189
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ**

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн
оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр
ашиг”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг
хүргүүлж байна.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Ерөнхий мэдээлэл	9
БҮЛЭГ 1. ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.	
<i>А.1. Орон нутгийн өмчит байгууллагын компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.</i>	<i>7</i>
<i>А.2 Компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого хангалтгүй, ТУЗ-ийн үүрэг чиглэлийг тодорхой болгож, үнэлж дүгнэх, хариуцлага тооцох журам, зааврыг боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.....</i>	<i>8</i>
БҮЛЭГ 2. ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ, АЛДАГДАЛТАЙ, ҮР АШИГГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА.....	11
<i>Б.1 Зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, баталдаггүй, аймгийн ИТХ-аас баталсан журам бүрэн хэрэгжээгүй байна.....</i>	<i>11</i>
<i>Б.2 Орон нутгийн өмчийн оролцоотой 5 байгууллагын орлого зорилтот түвшиндээ хүрээгүй, тасарсан байна.....</i>	<i>14</i>
<i>Б.3 Санхүүгийн үр ашгийн тооцоо шинжилгээ хийж, үр нөлөөг дүгнэдэггүй, их хэмжээний хэлцлийн үр дүнгээр орох ногдол ашиг бүрэн төвлөрөөгүй байна.....</i>	<i>16</i>
<i>Б.4 Конрактын гэрээнд бусад нэмэгдэл цалинг тодорхой тусгадаггүй, удирдлагын зардлыг төлөвлөдөггүй байна.....</i>	<i>19</i>
БҮЛЭГ 3. ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ, ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	23
<i>В.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.....</i>	<i>23</i>
<i>В.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хангалтгүй байна.....</i>	<i>25</i>
<i>В.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангасан ч төрийн байгууллагын мэдээллийн уялдаа хангалтгүй байна.....</i>	<i>27</i>
ДҮГНЭЛТ:	28
ЗӨВЛӨМЖ:	29
Холбогдох байгууллагын санал:	34
ХАВСРАЛТУУД:	35

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АК	Ажлын капитал
АКЭ	Ажлын капиталын эргэц
БО	Борлуулалтын орлого
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БМ	Бараа материал
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ХББЗА ОНӨААТҮГ	“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ШУТП	Шинжлэх ухаан технологийн парк
Эрдэнэт ус ДТС ОНӨХК	“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” орон нутгийн өмчит хувьцаат компани
ЭХ	Эргэлтийн хөрөнгө

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Эдийн засгийн үр ашгийн зорилтот түвшин	11
Хүснэгт 2	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт 3	ЭХЗХ-оос баталсан дулаан түгээх хангах үйл ажиллагааны зардал	14
Хүснэгт 4	Эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	14
Хүснэгт 5	Орлогын эх үүсвэрийн жагсаалт	15
Хүснэгт 6	Төлбөр хураамжийн төлөлт	16
Хүснэгт 7	Санхүүгийн тайланд хийсэн шинжилгээний үр дүн	17-18
Хүснэгт 8	Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	20
Хүснэгт 9	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл	23
Хүснэгт 10	Үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналтын зөрчлийн тоо	24
Хүснэгт 11	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын биелэлтийг дүгнэсэн байдал	24
Хүснэгт 12	Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил	25
Хүснэгт 13	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил	27

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил	26



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/09

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын удирдлагад хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Мөнхбат, аймгийн Засаг дарга С.Батжаргал нарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор /Г.Оргилмөрөн/, аудитор /Б.Бямбаатогтох, Б.Азжаргал, Т.Болормаа, Г.Даваасүрэн/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\mydoc\bichig hereg\tushaal\2022.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 09 дүгээр тушаалын хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /мян.төгрөг/
1	Орхон АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал өөртөө холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 2021 оны 6,7,10-р сард нийт 1,148,621 төгрөгийн илүү цагийн хөлс бодож олгосон.	03/67ОРА-2022/22-13-ШТА-ТД	Орхон АЗЗА ТӨХК	1,148.6
2	ЭДЦС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/76 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсан Эрчим хүчний зохицуулах хороог 1,916,000 төгрөгөөр илүү шагнаж урамшуулсан.	02/66ОРА-2022/22-13-ШТА-ТД	ЭДЦС ТӨХК	1,916.0
3	ХББЗА ОНӨААТҮГ-ын захирал нь 2021 онд баталсан "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын цалин ба нэмэгдэл олгох журам"-д тусгаагүй мэргэшлийн зэргийн нэмэгдэл 1,682.3 мянган төгрөгийг авсан.	05/69ОРА-2022/22-13-ШТА-ТД	ХББЗА ОНӨААТҮГ	1,682.3
4	Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ -ын захирал нь 2021 онд эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй, өөрийн гаргасан тушаалаар 4 удаа нийт 200.0 мянган төгрөгийн урамшуулал авсан.	04/68ОРА-2022/22-13-ШТА-ТД	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	200.0
5	"Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк" ОНӨААТҮГ нь Пенофасад ХХК-ийн өөрийн эзэмшлийн 49 хувиас 2021 оны ногдол ашгийг одоо хүртэл төвлөрүүлж аваагүй	06/115ОРА-2022/22-13-ШТА-ТД	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	27,444.2
Нийт дүн				32,391.1

D:\mydoc\bichig hereg\tushaal\2022.doc

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ, ОНӨГ зэргийн 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, ахлах аудитор В.Жавзмаа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Б.Бямбатогтох, Т.Болормаа, Б.Азжаргал, Г.Даваасүрэн, О.Хэрлэнзаяа нар 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын явцад
учирсан хүндрэл,
бэрхшээлүүд:**

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Ерөнхий мэдээлэл

Орхон аймгийн хэмжээнд 5 ОНӨААТҮГ, 1 ОНӨХК нийт 6 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь дулаан түгээх, ус хангамж ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ, цахилгаан түгээх болон цахилгаанаар зохицуулалттай хангах, барилга угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрлүүдийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ нь орон нутгийн хэмжээнд хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох судалгаа, бодлогын баримт бичиг боловсруулах ажилд хамтран оролцох, зөвлөх, шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, сургалт, инновацын үйл ажиллагаа эрхлэх, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

“Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ нь Эрдэнэт хотын нутаг дэвсгэрт баригдсан Бурхан багшийн сэрэг дүрийн барилга байгууламжийн дуусаагүй хэсгийн ажлыг үргэлжлүүлэн хийж, урьд нь чанар өнгө үзэмжийн шаардлага хангаагүй барилгыг сэргээн тохижилтыг зохион байгуулж дуусган, хүн ам сүсэгтэн олны болон дотоод гадаадын иргэдийн аялал жуулчлал, амралтын цогцолбор болгож, үр ашигтай ажиллах, улмаар орон нутагт орлогоо хандивлаж өөрийн өртгөө аль болох богино хугацаанд эргүүлэн олох зорилготой байгуулагдсан байна.

“ХББЗА” ОНӨААТҮГ нь барилгын төсөв санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилгыг бариулах, зураг төсөв техникийн норм, дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгаж, баталгаажуулах, барилгын гүйцэтгэгч байгууллагын зөрчил дутагдлыг засуулах, гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилгыг чанартай ашиглалтад оруулахад техникийн хяналт тавихаас гадна холбогдох байгууллага хэлтэс, албатай ерөнхий захиалагчийн өмнөөс үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ нь гэр бүлийн хөгжлийн сургалт, сурталчилгааны төв ажиллуулах, гэрлэх ёслолын зан үйлийн үйлчилгээгээр иргэдэд үйлчлэх, бэлэг дурсгалын зүйлийн худалдаа, үйлчилгээ эрхлэх, хуримын бөгж, титэм, үнэт эдлэлийн худалдаа, зуучлал, гэр бүлийн ёслолын цэнгүүн, нийтийн хоолны үйлчилгээ, нийтийн цэнгүүн, автомат тоглоомын үйл ажиллагаа явуулахаар байгууллагын дүрэмд тусгажээ.

БҮЛЭГ 1. ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

А.1. Орон нутгийн өмчит байгууллагын компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.

1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд компанийн засаглалын талаарх зохицуулалт тусгагдаагүй байна.

Орон нутгийн өмчит компанийн удирдлага, засаглал нь компанийн тухай хуулийн дагуу зохицуулж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын компанийн засаглал, төлөөлөн удирдах зөвлөл, эдгээртэй холбогдсон харилцааг бүрэн зохицуулаагүй байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн мөрддөг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд компанийн засаглалыг хөгжүүлэх асуудлын талаар тодорхой тусгах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсны дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 02 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, орон нутгийн өмчийн талаар баримтлах чиглэл, зарчим, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагын тогтолцоо, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах талаар тусгасан байна. Гэвч тус бодлогын хэрэгжилтийг хангуулсан эсэх нь тодорхой бус, үнэлж дүгнээгүй байна.

Орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн ТУЗ-д нийт 54 гишүүн ажиллаж байна. Компанийн тухай хуулийн 75.8-д “компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна” гэж заасан боловч ТУЗ-ийн 54 гишүүн сургалтад хамрагдаагүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлаагүй нь Компанийн тухай хуулийн 76.1.13, 75.8 дах заалтуудтай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ нь орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлогыг оновчтой тодорхойлж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ын гишүүдийг томилоход хууль, эрх зүйн шаардлагыг хангасан гишүүнээр томилох, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.1.2. Засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийх зохицуулалттай тул компанийн засаглалын үнэлгээг хийгээгүй байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 443 дугаар тогтоол “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж өгөхөөр заасны дагуу хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-ыг баталжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь журмын 3.2-д “Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно” гэж заасан болон засаглалын үнэлгээ хийлгэх тохиолдлууд нь орон нутгийн хуулийн этгээдийн хамааралгүйгээс шалтгаалан компанийн засаглалын үнэлгээ хийлгэдэггүй байна.

Эрдэнэт ус ДТС ОНӨХК хийсэн засаглалын үнэлгээ.

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Авбал зохих нийт оноо	Үнэлгээний оноо	Үнэлгээний хувь
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	40	17	42.5%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	16	6	37.5%
В	Оролцогч талуудын харилцаа	20	18	90.0%
Г	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	20	14	70.0%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороод	56	23	41%
Е	Гүйцэтгэх удирдлага	20	9	45.0%
	Нэгдсэн дүн	172	87	54.3%

(Үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс)

Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн нэгдсэн үнэлгээ нь 54.3 хувьтай дунд засаглалтай буюу удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсэж болзошгүй дүгнэлттэй байна.

Нэгдсэн үнэлгээний оноог бууруулж буй гол шалтгаан нь холбогдох дүрэм журмын зохицуулалт, хэрэгжүүлэлттэй холбоотой байна.

1.1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 3 байгууллага орон нутгаас санхүүжилт авч, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогод нийцүүлэн аймгийн ИТХ-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан байна.

Аймгийн ИТХ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, ОНӨГ-аас татан буулгах санал өгсөн 2 хуулийн этгээдээс 1-ийг татан буулгасан байна.

Тухайн хуулийн этгээдийг татан буулгахад хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул оновчтой зохион байгуулалт хийх талаар судлахаар болсон байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 6 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 3 нь өөрийн орлогоор санхүүжиж, 3 нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авч байгаад тооцоо, судалгаа хийж, ижил чиг үүргийн байгууллагуудад нэгтгэж шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих хэрэгтэй байна.

А.2 Компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого хангалтгүй, ТУЗ-ийн үүрэг чиглэлийг тодорхой болгож, үнэлж дүгнэх, хариуцлага тооцох журам, зааврыг боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.

1.2.1. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого хангалтгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат 2016 онд дууссан байна.

Тус хөтөлбөрийн “Монгол улсын компанийн засаглалын үндэсний тайлан”-г 2013, 2015 онд нэгтгэж олон нийтэд мэдээлжээ. Уг тайланд Монголын хөрөнгийн бирж болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д бүртгэлтэй ТӨХК-уудыг хамруулсан бөгөөд Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн санхүүгийн, компанийн засаглалын үнэлгээ нэгтгэгдсэн байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 2-ыг “Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага манлайлах” гэж тусган, зорилтын хүрээнд компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гарган хэрэгжүүлэх, хуулийн этгээдийн компанийн засаглалын төвшинг тогтоож олон нийтэд мэдээлэх, гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, хариуцлагын байдалд үнэлгээ хийж ангилал тогтоох, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын хариуцлага болон урамшууллыг компанийн засаглалын түвшинтэй уялдуулах талаар тусгасан.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 02 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого"-ыг баталсан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

Аймгийн Засаг даргын орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан контрактыг жил бүр дүгнэж, хэлэлцдэг ч тодорхой ахиц, үр дүн гараагүй байна. Иймд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн талаар баримтлах бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлж, үнэлж дүгнэх шаардлагатай болсон байна.

1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд өмчийн ашиглалт хамгаалалтын талаар арга хэмжээ авч ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1-д “төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” гэсэн арга хэмжээг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгаагүй байна.

Харин өмчийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд илүүдэлтэй, ашиглагдахгүй байгаа 5 байгууллагын 201.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад шилжүүлжээ.

Аймгийн Засаг дарга 2016-2020 онд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн захиралтай байгуулсан контрактыг дүгнэхдээ зөвлөлийн хурлаар үйл ажиллагааны үр дүнг хэлэлцжээ. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн алдагдалтай ажилласан, засаглалын үр нөлөө сул байгаа зэрэгт хариуцлага тооцоогүй байна.

1.2.3. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг 1 байгууллагыг татан буулгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэсэн арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаагүй байна.

Харин орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 473.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хөрөнгийн ангилал тус бүрээр бүртгэн, хяналт хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллого зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна. Мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг 1 хуулийн этгээдийг татан буулгаж, төсвийн байгууллагад үйл ажиллагааг нэгтгэжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын болон үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох шаардлагатай байна.

1.2.4. ТУЗ-ийн үүрэг чиглэлийг тодорхой болгож, үнэлж дүгнэх, хариуцлага тооцох журам, зааврыг боловсруулж мөрдөөгүй байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх бүхий байгууллага аймгийн ИТХ-аас тухайн хуулийн этгээдийн ТУЗ-ийг томилдог бөгөөд орон нутгийн сонгуулийн үр дүнгээс шалтгаалан өөрчлөгдөж, тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдэхгүй байна.

Томилогдсон ТУЗ-ийг төрийн байгууллагууд болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй хэрхэн ажиллах, үнэлж дүгнэх, хариуцлага тооцох талаар аймгийн хэмжээнд баримтлах дүрэм, журам байхгүй байна.

Компанийн тухай хуулийн 75.4-д "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэсэн хэсгийг үндэслэн ТУЗ-ыг томилж буй ч бүрэн хэрэгжээгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ нь жилийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бүтэц орон тоо батлах, цалин урамшуулал нэмэх зэрэг асуудлыг хэлэлцэж, жилд дунджаар 1-3 удаа тогтоол гаргаж, холбогдох асуудлыг шийдвэрлэж ажилладаг байна. Гэвч санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянахгүй баталж, үйл ажиллагааны үр дүнг хэлбэр төдий хэлэлцдэг, эрх зүйн актууд шинэчлэх эсэхэд үр нөлөөтэй ажилладаггүй байна. Тухайлбал:

- ХББЗА ОНӨААТҮГ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлаагүй, ТУЗ-ийн шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө худалдан авсан байна.
- Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ аймгийн ИТХ-аас баталсан бүтэц, орон тоог нэмэгдүүлэн баталж, албан хаагчдын гомдлын дагуу ИТХ-ын баталсан бүтэц, орон тоог мөрдөж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн ажиллах чиг үүрэг тодорхой бус, үнэлж дүгнэдэггүй, бүтэц орон тоо нэмэгдүүлж баталсан зэрэг нь тухайн байгууллагын үйл ажиллагаа үр дүнгүй болж, үргүй зардал өсөх, хариуцлага сулрах зэрэг эрсдэл үүсгэхээр байна.

Иймд ТУЗ-ийн үүрэг чиглэлийг тодорхой болгон, үнэлж дүгнэн, хариуцлага тооцох журам, зааврыг боловсруулж мөрдөх хэрэгтэй байна.

БҮЛЭГ 2. ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ, АЛДАГДАЛТАЙ, ҮР АШИГГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА.

Б.1 Зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, баталдаггүй, аймгийн ИТХ-аас баталсан журам бүрэн хэрэгжээгүй байна.

2.1.1. Эдийн засгийн зорилтот түвшнийг биелэх боломжтой эсэхийг тооцоо судалгаанд тулгуурлан төлөвлөдөггүй байна.

Орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдээс 4 хуулийн этгээд жил бүр бүтэц орон тоо, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үр ашиг, тухайн жилийн зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төлөвлөн, ТУЗ-аар батлуулсан байна.

Орон нутгийн өмчит 2 хуулийн этгээд болох “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа” УТҮГ, “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс 100% санхүүждэг.

“Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-аас баталсан ТУЗ-тэй боловч аудитад холбогдох баримт, мэдээллээ ирүүлээгүй болно.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшинг ТУЗ-аас дараах байдалтай баталжээ.

хүснэгт №1 Эдийн засгийн үр ашгийн зорилтот түвшин /сая.төгрөг/						
№	Зорилтот түвшний үзүүлэлт	Он	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	ХББЗА ОНӨААТҮГ	Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ
1	Орон тоо	2019	322	19	21	5
		2020	329	21	15	5
		2021	319	24	9	6
2	Орлого	2019	15,321.0	465.8	912.9	88.3
		2020	17,800.8	512.7	799.0	78.6
		2021	20,295.7	573.9	656.0	79.7
3	Зарлага	2019	16,161.1	438.4	647.9	87.9
		2020	18,799.5	511.6	735.0	78.4
		2021	21,011.5	560.2	682.4	79.6
4	Ашиг алдагдал	2019	(840.1)	27.4	265.0	0.4
		2020	(998.7)	1.1	64.0	0.2
		2021	(715.8)	13.7	(26.4)	0.1

ОНӨААТҮГ-ууд нь эдийн засгийн зорилтот түвшинг боловсруулахдаа өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулдаг гэх боловч орлогын төлөвлөгөө бүрэн биелэх

боломжтой эсэхийг нягталж, баталгаажуулсан тооцоо судалгаагүй тоон үзүүлэлтийг оруулж батлуулдгаас орлогын төлөвлөгөө бүрэн биелэх боломжгүй байна.

Орлогын төлөвлөгөөнд орон нутгаас авах дэмжлэг санхүүжилт, харилцах дансны өмнөх оны үлдэгдэл, санхүүгийн тайланд тусгасан авлага зэргийг тусгадгаас тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болох орлого бүрдүүлэлтийг хангах зорилгоор эдийн засгийн зорилтот түвшинг боловсруулдаггүй байна.

Эрдэнэт ус ОНӨХК-ийн 2019, 2021 оны, Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн зорилтот түвшинг алдагдалтай байхаар тус тус баталжээ.

хүснэгт №2		Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл				/сая төгрөг/
№	Он	Зарлагын төлөвлөгөө, биелэлт	Эрдэнэт ус ОНӨХК	ХББЗА ОНӨААТҮГ	Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ
1	2019 он	Төлөвлөгөө	16,161.1	438.4	647.9	87.9
		Гүйцэтгэл	17,451.0	394.5	603.5	72.7
		Зөрүү	1,289.9	(43.9)	(44.4)	(15.2)
2	2020 он	Төлөвлөгөө	18,799.5	511.6	735.0	78.4
		Гүйцэтгэл	18,902.4	435.6	560.6	72.7
		Зөрүү	(102.9)	(76.0)	(174.5)	(5.7)
3	2020 он	Төлөвлөгөө	21,011.5	560.2	682.4	79.6
		Гүйцэтгэл	20,856.8	544.6	565.2	87.5
		Зөрүү	154.7	(15.6)	(117.2)	7.9

“Эрдэнэт ус” ОНӨХК-ын зардал нь төлөвлөгөөнөөс хэтрэлттэй байгаа нь орлого давж биелсэнтэй холбоотой зардлууд нэмэгдэх, оны дундуур нэмэгдэж ирсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцоололгүй нэмэгдэх, дамжих ус дулааны зардал төлөвлөгөөнөөс давах зэргээс шалтгаалж зардлын хэтрэлт үүсдэг. Санхүүгийн жилийн дундуур эдийн засгийн зорилтот түвшингийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулж эдийн засгийн зорилтот түвшинд тодотгож, ТУЗ-аар батлуулдаггүй байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 5.3-т “орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирал жил бүрийн 7 дугаар сарын 01-ны дотор байгууллагын зорилт, түүнийг хэрэгжүүлэх төсвийн төслийг Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлээд аймгийн Өмчийн харилцааны газарт хүргүүлнэ”, 5.4-т “аймгийн Өмчийн харилцааны газар орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсвийн төслийг хянан нэгтгэж, санал дүгнэлтийн хамт 7 дугаар сарын 15-ны дотор аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлнэ”, 5.5-д “аймгийн ЗДТГ-ын СТСХ орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагын тухайн жилийн төсвийн саналыг хянан, хуулийн этгээдийн удирдлагатай 12 дугаар сарын 01-ны дотор эцэслэн тохиролцож, 12 дугаар сарын 31-ны дотор аймгийн Засаг даргаар батлуулна” гэсэн заалтууд огт хэрэгжээгүй байна.

ОНӨААТҮГ-ууд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч тухайн жилд бодит орох боломжтой орлогыг тооцоолж төлөвлөдөггүйгээс баталсан эдийн засгийн зорилтот түвшин хангагдахгүй байх эрсдэлтэй тул тооцоо судалгаанд тулгуурлан, орлогоо төлөвлөж, ТУЗ-аар батлуулах шаардлагатай байна.

2.1.2. Эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ хянахгүйгээр баталж, аймгийн ИТХ-аас баталсан журам бүрэн хэрэгжээгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшинг хэлэлцүүлэхдээ дараа оны эхний улиралд багтаан, хурал болохоос 7-10 хоногийн өмнө бизнес төлөвлөгөө, тайлант оны гүйцэтгэл зэргийг ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлдэг байна.

Тухайн байгууллагуудын ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд бизнес төлөвлөгөө хэлэлцэх явцад орлого бүрэн биелэх боломжтой эсэх, давж биелсэн шалтгаан, зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, орон тоо болон цалин, урамшуулал нэмэх үндэслэл, шалтгааныг тодруулсан талаарх тэмдэглэл хөтлөөгүй, ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар баталсан байна. Мөн түүнчлэн ТУЗ-ийн гишүүд бизнес төлөвлөгөөнд тусгасан тоон мэдээлэл бодитой эсэхийг тулгаж, хянаагүйг илтгэж байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-д зааснаар эдийн засгийн зорилтот түвшинг ТУЗ хэлэлцэн, орон нутгийн өмчийн газар болон аймгийн ЗДТГ-ын СТСХ хянаснаар аймгийн Засаг дарга батлахаар тусгасан байтал зөвхөн ТУЗ баталж, төрийн байгууллагуудын хяналт огт хэрэгжээгүй байна.

Аймгийн ИТХ болон ОНӨГ-аас дээрх журмын хэрэгжилтийг хангах үүднээс ОНӨААТҮГ болон ОНӨХК-уудад энэ талаарх арга зүйн зөвлөгөө өгч ажиллан, эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй эсэхийг нягтлан хянаж, анхан шатны баримтаар баталгаажуулах шаардлагатай байна.

2.1.3. Эдийн засгийн зорилтот түвшнийг зөвхөн ТУЗ, “Эрдэнэ Ус ДТС” ОНӨХК-ийн цахилгаан, дулааны зардлыг эрчим хүчний зохицуулах хороо хянаж, баталдаг байна.

Орон нутгийн өмчит газруудын эдийн засгийн зорилтот түвшинг ТУЗ баталдаг бөгөөд өөр эрх бүхий байгууллага хянаж батлаагүй байна.

Эрдэнэт ус ДТС ОНӨХК-аас Эрчим хүчний зохицуулах хороонд 2020 онд 100 төгрөг тутмын 39.42 төгрөгийг, 2021 онд 38.97 төгрөг тутмыг өөрт үлдэхээр тооцож санал хүргүүлсэн бол Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 357 тогтоолоор 36.2 төгрөг, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолоор 34.42 төгрөг, 2021 оны 01 дүгээр 27-ны өдрийн 53 дугаар тогтоолоор 31.21 төгрөгөөр тус тус баталж, дулаан түгээх хангах үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг жил бүр хянан, үнэлэлт өгсөн байна.

Хүснэгт №3 ЭХЗХ-оос баталсан дулаан түгээх хангах үйл ажиллагааны зардал

№	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт + Хэмнэлт -
1	2019	2,189.5	2,443.6	254.1
2	2020	2,366.2	2,691.7	325.5
3	2021	2,345.9	2,847.1	501.1

Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр 23-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2019 оны зорилтын биелэлтийг "сайн", дулаан түгээх дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл шаардлагын биелэлтийг "дунд", 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 318 дугаар тогтоолоор цахилгааны нөхцөл шаардлагыг "дунд", дулааны нөхцөл шаардлагыг "сайн", 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор цахилгааныг "хангалттай сайн", дулааныг "сайн" гэж тус тус үнэлжээ.

Зардал хэтрэх гол шалтгаан нь элэгдлийн зардал, цалингийн зардал, цахилгааны зардлыг хүргүүлсэн саналаас хэт багаар баталж өгсөнтэй холбоотой байна.

Б.2 Орон нутгийн өмчийн оролцоотой 5 байгууллагын орлого зорилтот түвшиндээ хүрээгүй тасарсан байна.

2.2.1.Орон нутгийн өмчит 5 хуулийн этгээд нь төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2019-2021 оны төлөвлөсөн орлого, орлогын төлөвлөгөөний биелэлтээр авч үзвэл 1 хуулийн этгээд төлөвлөсөн орлогын төлөвлөгөөгөө жил бүр давуулан биелүүлж, 5 нь төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт № 4 Эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төгрөг/

№	Он	Орлогын төлөвлөгөө, биелэлт	Эрдэнэт ус ОНӨХК	ХББЗА ОНӨААТҮГ	Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ
1	2019 он	Төлөвлөгөө	15,321.0	465.8	912.9	88.3	42.8	9.4
		Гүйцэтгэл	16,544.4	413.4	790.1	70.3	70.0	9.4
		Зөрүү	1,223.5	(52.5)	(122.8)	(18.0)	27.2	0
2	2020 он	Төлөвлөгөө	18,110.8	512.7	799.0	78.6	43.4	139.4
		Гүйцэтгэл	18,370.3	528.8	606.9	50.2	55.9	78.3
		Зөрүү	259.5	16.1	(192.1)	(28.4)	12.5	(61.1)
3	2020 он	Төлөвлөгөө	20,295.7	573.9	656.0	79.7		179.4
		Гүйцэтгэл	20,858.4	499.3	591.3	67.2	64.7	168.1
		Зөрүү	562.7	(74.6)	(64.7)	(12.5)	(64.7)	(11.3)

“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-ийн орлого жил бүр давж биелсэн нь шинээр барилга байгууламж, орон сууц ашиглалтад орох, эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтөөс шалтгаалдаг бол “ХББЗА” ОНӨААТҮГ, “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ,

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ууд нь өөрийн үйл ажиллагаанаас төвлөрөх орлогыг бодитой бус төлөвлөж батлуулснаар орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөдөг ч 2019-2021 онуудад цар тахлаас шалтгаалан төлөвлөсөн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа” УТҮГ, “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс санхүүжсэн байна.

Хүснэгт №5		Орлогын эх үүсвэрийн жагсаалт				/сая төгрөг/	
№	Байгууллагын нэр	2019 он		2020 он		2021 он	
		Өөрийн орлого	Орон нутгаас	Өөрийн орлого	Орон нутгаас	Өөрийн орлого	Орон нутгаас
1	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ	540.1	250.0	190.2	416.7	280.3	311.0
2	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ		70.0		55.9		64.7
3	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ		9.4		78.3		168.1
4	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	41.2		50.2	29.8	70.3	29.0
	Нийт дүн	581.3	329.4	240.4	580.7	350.6	572.8

“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа” УТҮГ орон нутгийн төсвөөс санхүүжиж, үйл ажиллагаа явуулж буй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дах заалттай нийцэж байна.

“Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ, “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс санхүүжин, үйл ажиллагаа явуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дах заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-аас “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ-тай хамтран иргэдийн гарааны бизнесийг дэмжих зорилгоор иргэдэд сургалтын зардал, өрхийн үйлдвэрлэл, гарааны бизнесийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд нийт 977.7 сая төгрөгийг 2 аж ахуй нэгж, 199 иргэнд олгожээ. Энэ нь байгууллагын дүрмийн 1.1-д “орон нутгийн хэмжээнд хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох судалгаа, бодлогын баримт бичиг боловсруулах ажилд хамтран оролцох, зөвлөх, шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, сургалт, инновацын үйл ажиллагаа эрхлэх, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага мөн” гэсэн заасантай нийцэхгүй байна.

“Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны бизнес төлөвлөгөөг 2019 онд баталж, 2021 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ батлаагүй бөгөөд бизнес төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаагүй байна.

Зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дүрэмд заасан үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг нь эрхлүүлэх, орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үйл ажиллагааг ижил төстэй төсвийн байгууллагад нэгтгэх, оновчтой зохион байгуулалт хийх шаардлагатай байна.

2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар төлбөр хураамжийн 98.4 хувийг төвлөрүүлжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 2019-2021 онуудад улсын төсөвт 1,634.6 сая төгрөг, орон нутгийн төсөвт 1,041.9 сая төгрөг, Нийгмийн даатгалын санд 3,132.1 сая төгрөг, нийт төлбөл зохих төлбөрийн 98.4 хувийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 6 Төлбөр хураамжийн төлөлт /сая.төгрөг/

№	Он	Орлогын төлөвлөгөө, биелэлт	Орон нутгийн төсөвт	Улсын төсөв	Нийгмийн даатгалын сан
1	2019 он	Төлбөл зохих	325.57	576.0	929.4
		Төлсөн	341.4	569.2	929.8
		Авлага/өглөг	22.3	(6.8)	0.4
2	2020 он	Төлөвлөгөө	369.0	513.3	1,069.0
		Гүйцэтгэл	329.6	501.3	1,072.6
		Зөрүү	(18.0)	(12.0)	4.0
3	2021 он	Төлөвлөгөө	336.4	646.0	1,140.8
		Гүйцэтгэл	370.9	564.6	1,129.7
		Зөрүү	1.3	(81.4)	(6,4)
4	Нийт	Төлөвлөгөө	1,031.0	1,735.3	3,139.2
		Гүйцэтгэл	1,041.9	1,635.1	3,132.1
		Зөрүү	5.6	(100.2)	(2.0)

Улсын төсөвт 100.2 сая төгрөг, Нийгмийн даатгалын санд 2.0 сая төгрөгийн өглөгтэй, орон нутгийн төсвөөс 5.6 сая төгрөгийн авлагатай байна.

Авлага нь өмнөх онд илүү төвлөрүүлсэнтэй холбоотой бол өглөг үүссэн шалтгаан нь цар тахлын үед төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж чадаагүйтэй холбоотой байна. Өглөгийг байгууллагын дараа оны бизнес төлөвлөгөөнд тусгаж, барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Б.3 Санхүүгийн үр ашгийн тооцоо шинжилгээ хийж, үр нөлөөг дүгнэдэггүй, их хэмжээний хэлцлийн үр дүнгээр орох ногдол ашиг бүрэн төвлөрөөгүй байна.

2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг огт хийдээгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээ хийдэггүй байна.

Аудитаар орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн орлого үр дүнгийн тайланд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. /Хавсралт№01/ Үүнд:

- “ХББЗА” ОНӨААТҮГ нь сүүлийн 3 жилийн турш ашигтай ажиллажээ. 2019 онд нийт борлуулалтын орлогын 244.0 сая төгрөг буюу 59%, 2020 онд 263.9 сая буюу 50%, 2021 онд 429.8 сая буюу 86%-ийг өмнөх онуудад хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын зардлын санхүүжилт эзэлж байна. Өмнөх онуудад хэрэгжсэн төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг тухайн оны орлогоор хүлээн зөвшөөрдөг бөгөөд тайлант онд авлагаар бүртгэж тайлагнаагүйгээс ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

- “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ нь 2019, 2020 онуудад ашигтай ажилласнаар тайлагнажээ. Аймгийн Засаг даргын 2019 оны А/686 дугаар захирамжаар өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор нэг өрх-нэг ажлын байр зорилтын хүрээнд төсөл сонгон шалгаруулалт хийж олгох 122.0 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй, зээлийн төлбөр нь нийт орлогын 18%, 2020 онд олгосон 200.0 сая төгрөг нь нийт орлогын 35%-ийг тус тус тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Мөн аймгийн ЗДТГ-тай аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил, техник технологийн судалгаа эрхлэх, боловсон хүчин бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх гэж, гэрээ байгуулан, 2019 онд 250.0 сая төгрөг, 2020 онд 216.7 сая төгрөгийн дэмжлэг санхүүжилт авч санхүүгийн эх үүсвэрийн 37%-ийг бүрдүүлж, ашигтай ажиллахад гол нөлөө үзүүлсэн байна.
- “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ, “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ-ууд 100% орон нутгийн төсвөөс санхүүжсэн бол “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ нь ажил гүйцэтгэх гэрээ, зээл олгох зэргээр орон нутгаас санхүүжилт авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

“ХББЗА” ОНӨААТҮГ-аас бусад ОНӨААТҮГ-ууд жил бүр алдагдалтай ажиллаж, орон нутгийн төсвөөс санхүүжиж, өөрийн орлогыг бүрдүүлэхгүй ажилласаар байхад ТУЗ-ын гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Аудитаар орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдээс үйл ажиллагааны орлого, цар хүрээ ихтэй “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №7		Санхүүгийн тайланд хийсэн шинжилгээний үр дүн			
Санхүүгийн харьцаа	Тооцсон үзүүлэлт	Зохих түвшин	2019 он	2020 он	2021 он
БМ-ын эргэц /удаа/	ББӨ:БМ	5.0-10.0	17.6	18.7	20.08
БМ-ын насжилт	360/БМ-ын эргэц	30-70 хоног	20.44	19.24	17.92
Авлагын эргэц /хоног/	360/авлагын удаа	эргэц- 30-70 хоног	94.59	188.03	219.76
Өглөгийн эргэц	360/өглөгийн удаа	эргэц- 30-70 хоног	148.56	306.27	317.24
Ажлын капиталын эргэц /АКЭ/	БО/АКЭ*АК=ЭХ-Эр.Өр. төл		14.47	7.14	5.83
Нийт хөрөнгийн эргэц	БО/Нийт дундаж хөрөнгийн		0.60	0.32	0.34
Мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөг	БМ-ын насжил/хоног/+авлагын эргэц-Өглөгийн эргэц	<60 хоног	(33.52)	(99.0)	(79.56)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА: Бараа материалын эргэц суурь өндөр байгаа нь тус компанийн хувьд бараа материалыг хэт ихээр нөөцөлж, бараа материалын ашиглалт муу байгааг илэрхийлж байна.

Авлагын төлөгдөх хугацаа жил ирэх тутам удааширсаар байна. 2020 онд суурь оноос 2 дахин, 2021 онд 2.3 дахин удааширсан байна.

Жилээс жилд усны алдагдал ихсэж, үүнтэй холбоотой авлагын өсөлт нэмэгдэж байгаа нь авлагын эргэцэд хамгийн их сөрөг нөлөөг үзүүлж байна. Иймээс тус компанийн хувьд авлагын удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Жил тутам өглөгийн эргэц удааширч байгаа нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас хүлээн авсан усны объёмын зөрүүгээс үүсэж буй алдагдалтай холбоотой өр төлбөрийн өсөлт жилээс жилд нэмэгдэж байгаатай шууд холбоотой юм.

Ажлын капиталын эргэц суурь онд 1 төгрөгийн эргэлтийн хөрөнгө тутмаас 14.5 төгрөгийн орлого олдог байсан бол 2020 онд 7.1 төгрөг, 2021 онд 5.8 төгрөг болж жил тутам буурсаар байна.

Нийт хөрөнгийн эргэц суурь оноос 0.28 болон 0.26 функтээр буурсан нь нийт хөрөнгийн ашиглалт муудаж байгааг илэрхийлж байна. Суурь онд нийт хөрөнгийн 1 төгрөгийн ашиглалт тутмаас 60 мөнгөний үр өгөөж хүртдэг байсан бол энэ нь 2020 онд 32 мөнгө, 2021 онд 34 мөнгө болж буурсан байна. Энэ нь ажлын капиталын бодлого муудаж, эргэлтийн хөрөнгийн эргэц удааширч байгаатай холбоотой байна.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА: Мөнгөн хөрөнгийн мөчлөг сөрөг үзүүлэлттэй байгаа нь авлага болон бараа материалын эргэцээс өглөгийн эргэц удаашралтай байгааг илтгэж байгаа бөгөөд компани өр төлбөрөө барагдуулах чадвар муудсаныг илтгэж байна.

Эдгээрээс үзэхэд тус компанийн үйл ажиллагааны зардал өндөр, зардлыг хямдруулах, хянах бодлого сул байгааг илтгэж буй бөгөөд компанийн хувьд авлагын удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлж, бараа материалын ашиглалтыг сайжруулан, өр төлбөрөө барагдуулах чадварыг сайжруулж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна. Байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ТУЗ нь санхүүгийн үр ашгийн шинжилгээг хийж, дүн шинжилгээг нэгтгэн хэлэлцэж, үйл ажиллагааны үр дүнг тооцох шаардлагатай байна.

2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээ хийдэггүй, үр нөлөөг үнэлж дүгнэдэггүй байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд жил бүр санхүүгийн алдагдалтай ажиллаж байна. Аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 5.8-д "Өмчийн харилцааны газар, Төлөөлөн удирдах зөвлөлтэй хамтран батлагдсан зорилтын санал, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн хүрэх зорилтот түвшний үзүүлэлтүүдийг гэрээ, контракт дүгнэх үндсэн шалгуур үзүүлэлт болгоно", аймгийн ИТХ-ын 2016 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого"-ын 4.2.4-т "орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот

үйлдвэрийн газруудын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, үйлчилгээний тарифыг хатуу барих төрийн бодлого болон бусад нөхцөлийн улмаас үүссэн алдагдлыг тухай бүр судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллана” гэсэн заалтын хэрэгжилт хангагдахгүй байна. /Хавсралтаар дэлгэрэнгүй харуулав./

ОНӨГ болон ОНӨААТҮГ-ын удирдлага, ТУЗ нь санхүүгийн ашигт ажиллагааг дээшлүүлэх, санхүүгийн чадавхийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хяналт хэрэгжүүлж, аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоол болон 2016 оны 2 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

2.3.3. Өөрийн эзэмшлийн ногдол ашгийг бүрэн төвлөрүүлж аваагүй байна.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК болон орон нутгийн өмчит 4 хуулийн этгээд нь их хэмжээний гэрээ хэлцэл хийгээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 13/02 дугаар тогтоолоор “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны орлогоос аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 140.0 сая төгрөгөөр “Гарааны үйлдвэрлэл-2019” төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан байна. Ингэснээр “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолоор иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн гарааны үйлдвэрлэлийн төсөлд 100 хүртэл сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх зарчмаар хуулийн этгээдийн 49 хувийг эзэмших, хувь нийлүүлсэн үйлдвэрлэлийн хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулж, ТУЗ-д төлөөлөл томилон ажиллуулах, үр дүнг тайлагнахаар тусгажээ.

“Гарааны үйлдвэрлэл-2019” төслийн ажлын хэсгийн хуралдаанаар барилгын хуурай хольц, бэлэн материалын үйлдвэрийн төслийг дэмжиж 100.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 88.1-т “Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Барилгын хуурай хольц, бэлэн материалын үйлдвэрийн Пенофасад ХХК-ийг 2020 оны 1 дүгээр сард үүсгэн байгуулж, тус компанийн 49 хувийг “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ эзэмшжээ. Пенофасад ХХК-ийн өөрийн эзэмшлийн 49 хувиас 2021 оны ногдол ашиг 27.4 сая төгрөгийг одоо хүртэл төвлөрүүлж аваагүй байгаа нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т “компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна”, Пенофасад ХХК-ийн дүрмийн 4.2-т “ногдол ашгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувиар талуудад мөнгөн хэлбэрээр компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас сар бүр хуваарилна” гэсэн хэсэгтэй нийцэхгүй байна. Ногдол ашгийн төлбөрийг өнөөдрийг хүртэл төвлөрүүлж аваагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Б.4. Контрактын гэрээнд бусад нэмэгдэл цалинг тодорхой тусгадаггүй, удирдлагын зардлыг төлөвлөдөггүй байна.

2.4.1. “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК удирдлагын зардлыг төлөвлөж, зарцуулдаг бол бусад ОНӨААТҮГ-ууд удирдлагын зардлыг төлөвлөдөггүй байна.

Орон нутгийн өмчит 5 хуулийн этгээд нь удирдлагын зардлыг төлөвлөж, тайлагнадаггүй, нийт зардлын дүнгээр төлөвлөн, тайлагнадаг бол Эрдэнэт Ус ДТС ОНӨХК төлөвлөж, зарцуулалтыг хянадаг байна.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь удирдлагын зардлыг ТУЗ-аар батлуулж, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна. Удирдлагын зардалд удирдах 6 албан тушаалтны цалин, гүйцэтгэх захирлын автомашины шатахуун, урсгал засварын зардал, албан томилолтын зардал, нийгэм хамгааллын зардал, хөдөлмөр хамгааллын зардлууд, холбоо, бичиг хэргийн зардлууд багтдаг байна.

Хүснэгт№8		Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл				/сая.төгрөг/	
№	зардал	2019 он		2020 он		2021 он	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Үндсэн цалин	103.0	106.1	118.8	120.8	118.8	115.8
2	НДШ	13.9	13.6	16.0	15.6	16.0	15.5
3	Урсгал засвар сэлбэг	2.4	0.3	6.0	0.2	11.0	0.1
4	түлш шатахуун	11.4	11.9	11.4	10.9	10.0	9.3
5	албан томилолт	5.6	4.2	6.4	1.1	2.7	0.4
6	бичиг хэрэг	1.7	0.8	1.4	0.6	1.4	0.9
7	холбоо	1.1	1.0	1.1	0.8	1.1	0.7
8	хөдөлмөр хамгаалал	0.2	0.1	1.5	1.6	0.3	0.4
9	нийгэм халамж	0.2	0.8	0.2	0.9	0.2	0.4
10	Бусад үндсэн үйл ажиллагаа	3.9	3.6	4.3	3.0	2.9	0.7
	Нийт дүн	143.5	142.5	167.2	155.5	164.4	144.3

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь ТУЗ-ын 2019 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тухайн оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 5%-аар, 34 дүгээр тогтоолоор 2019 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс 5%-аар, 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 5 дугаар тогтоолоор 20%-аар тус тус үндсэн цалинг нэмэгдүүлснээс шалтгаалж цалингийн зардал хэтэрсэн бөгөөд цалин нэмэхтэй холбоотойгоор эдийн засгийн зорилтот түвшинд тодотгол оруулаагүй байна.

Удирдлагын зардлыг 2020 онд 167.2 сая төгрөгөөр, 2021 онд 164.4 сая төгрөгөөр баталж өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 10-д “**Ерөнхий ба удирдлагын зардал**”-д “Ерөнхий ба удирдлагын зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны болон хөгжүүлэлтийн зардал болон бусад гэж тодруулна” гэж заасан байтал ОНӨААТҮГ-ууд ерөнхий ба удирдлагын зардлыг тусад нь ангилан бүртгээгүй, нийт зардалд нэгтгэж тайлан бүртгэлд тусгасан байна. Иймд

ОНӨААТҮГ-ууд удирдлагын зардлыг нийт зардлаас тусад нь төлөвлөж, гүйцэтгэлийг гаргаж, санхүүгийн тайлан тооцоонд зохих журмын дагуу тайлагнаж, НБББББ-т тодорхой тусгах шаардлагатай байна.

2.4.2. Контрактын гэрээнд бусад нэмэгдэл цалинг тодорхой тусгадаггүй, шагнал цалинг тогтоосон журмын дагуу үнэлж дүгнээгүй байна.

Орон нутгийн өмчит 5 хуулийн этгээд нь эдийн засгийн зорилтот түвшинд нийт орон тоо болон цалин урамшууллын хэмжээг ТУЗ-өөр батлуулж ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т “орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох”, 78.3-т “орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах” гэж заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилон, контрактын гэрээ байгуулж, гэрээнд цалин хөлсийг тусгажээ.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь ТУЗ-ын 2019 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тухайн оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 5%-аар, 34 дүгээр тогтоолоор 2019 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс 5%-аар, 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 5 дугаар тогтоолоор 20%-аар тус тус үндсэн цалинг нэмэгдүүлжээ.

“ХББЗА” ОНӨААТҮГ нь ТУЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор 10%-аар, “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ нь ТУЗ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 3 дугаар тогтоолоор ажилчдын үндсэн цалинг тодорхой хэмжээгээр нэмж ажиллах шийдвэр гаргасны дагуу байгууллагын захирлын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар тушаалаар 15%-аар нэмэгдүүлсэн байна.

Дээрх байгууллагууд нь ТУЗ-ийн шийдвэрээр үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлж байгаа ч гүйцэтгэх захирлын цалинг ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн нэмэгдүүлэх талаар үйл ажиллагааны журам болон аймгийн Засаг даргатай байгуулсан контрактын гэрээнд тодорхой тусгасан зүйл заалт байхгүй, ТУЗ-ийн цалин нэмсэн шийдвэртэй уялдуулж тухайн оны контрактын гэрээг дахиж байгуулж баталгаажуулаагүй байна. Мөн ТУЗ-ийн тогтоолоор цалинг нэмж байгаа ч оны эхэнд баталсан эдийн засгийн зорилтот түвшнийг тодотгож, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг батлуулаагүйгээс дээрх байгууллагуудын цалингийн зардал анх баталсан зардлаас хэтэрсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-д “цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал” гэж заасан байтал аймгийн Засаг даргатай байгуулсан контрактын гэрээний 6.1-т үндсэн цалингийн хэмжээ, 6.2-т “захиралд контрактын хавсралтаар баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт, компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр ашгийн байдал, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, дараа оны ажлын бэлтгэл зэргийг харгалзан аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит байгууллагуудад төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу “Хангалттай” үнэлгээ авсан нөхцөлд

урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ” гэж зааснаас бусад нэмэгдлийг хэрхэн олгох талаар тодорхой заалт байхгүй байна. Иймд контрактын гэрээнд захирлын үндсэн цалин болон бусад нэмэгдлийг тодорхой тусгаж байх шаардлагатай байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн цалин, урамшууллын системд нийтлэг зөрчил дутагдлууд байна. Үүнд:

- “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь сар бүрийн шагналт цалинд 2019 онд 406.8 сая, 2020 онд 459.4 сая, 2021 онд 460.9 сая төгрөг тус тус зарцуулжээ. Захирлын 2018 оны А/59 дүгээр тушаалаар “ажилтнуудад шагналт цалин олгох журам”-ыг баталж, журамд зааснаар албан тушаал бүрээр шагналын үндсэн үзүүлэлт, олгох шагналын хэмжээ, бууруулах болон олгохгүй байх нөхцөл шаардлагыг тодорхой тусгасан боловч гүйцэтгэх захирлын шагналт цалинг олгох шаардлагыг журамд тодорхой заагаагүй байна. Аудитаар цалингийн анхан шатны баримтыг тулган баталгаажуулахад журмын дагуу шагналт цалингийн үнэлгээг бодоогүй, нийт ажилтнуудад хавтгайруулан үндсэн цалингийн 20%-аар, ТУЗ-ийн шийдвэргүйгээр гүйцэтгэх захиралд шагналт цалинг сар бүр 20%-аар тооцож олгосон байна. Иймд байгууллагын шагналт цалин олгох журамд гүйцэтгэх захиралд шагналт цалин олгох нөхцөл шаардлагыг тодорхой тусгах эсвэл ТУЗ-ийн шийдвэрээр олгож байх талаар зөвлөмж хүргүүлэв.
- “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ өмнөх онуудад ажилчдад урамшуулалт цалин олгож байгаагүй бөгөөд 2021 онд захирлын А-21/19 тушаалаар 2 ажилтанд 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 1.6 сая төгрөг, А/21/09 тушаалаар менежерт нэг удаагийн тэтгэмж 3.0 сая төгрөгийг тус тус олгосон байна. Тус газрын захирлын 2017 оны А-17/01 тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8 дах зүйл “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмж”-д урамшуулал, тэтгэмж олгох нөхцөл, шаардлагыг тодорхой тусгаагүй бөгөөд ажилтанд урамшуулал, тэтгэмж олгохдоо хамт олны хурлын тэмдэглэлээр баталгаажуулдаггүй байна. Иймд хөдөлмөрийн дотоод журамд тэтгэмж, урамшуулал олгох нөхцөл, шаардлагыг тодорхой тусгах талаар зөвлөмж хүргүүлсэн.
- ХББЗА ОНӨААТҮГ-ын захирал нь 2021 онд баталсан “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын цалин ба нэмэгдэл олгох журам”-д тусгаагүй мэргэшлийн зэргийн нэмэгдэл 1.7 сая төгрөгийг авсан нь журмын 4.3.3-д “мэргэшлийн зэрэгтэй ажилтан нь мэргэжлээрээ ажиллахад мэргэшлийн зэргийн дээд хэмжээг ажилтны сарын цалингийн хэмжээнээс дор дурдсан хувиар байгууллагын захирлын шийдвэрээр сар бүр олгоно. Үүнд: мэргэшсэн инженер, мэргэшсэн архитектор, мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн нягтлан бодогч-10%, зөвлөх инженер, зөвлөх архитектур, тэргүүлэх төсөвчин, мэргэшсэн нягтлан бодогч /хугацаагүй/-15%” гэсэн заалттай нийцэхгүй байх тул төлбөрийн акт тогтоосон.

2.4.3. Төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг техникийн комисс болон өмч хамгаалах комиссын дүгнэлтийг үндэслэж тооцсон байна.

Орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдээс 3 байгууллага /Эрдэнэт ус ДТС ОНӨХК, Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ, ХББЗА ОНӨААТҮГ/ ТУЗ-өөр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулсан байна.

Хөрөнгө оруулалтын баталсан төлөвлөгөөнд барааны үнийн өсөлт, тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон зэргээс хамаарч тодотгож баталжээ.

“ХББЗА” ОНӨААТҮГ нь 2020-2021 онд 11.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлаагүй хөрөнгө бэлтгэж, шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь гэнэтийн аваар, саатлаас шалтгаалж техникийн комисс, өмч хамгаалах комиссын дүгнэлтээр аваарын зардлаар худалдан авалт хийдэг бөгөөд ТУЗ-ийн шийдвэрээр эдийн засгийн зорилтот түвшинд тодотгол оруулдаг байна.

Хүснэгт №9 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төг/

№	Хуулийн этгээд	Тайлант он	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Эрдэнэт ус ДТС ОНӨААТҮГ	2019	761.9	690.3	71.6
		2020	1,422.7	1,317.8	104.9
		2021	1,044.0	850.4	193.9
2	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ	2019	30.1	29.4	0.7
		2020	53.4	52.7	0.4
		2021	28.1	27.8	0.3
3	ХББЗА ОНӨААТҮГ	2019	23.6	20.7	2.9
		2020	29.7	25.1	4.6
		2021	69.5	43.3	26.2

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэлээр хэмнэлттэй байгаа нь бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалж төлөвлөсөн үнээр авч чадахгүй болсон, тендер сонгон шалгаруулалт зарласан болов ч оролцох байгууллага байхгүйн улмаас тендер хүчингүй болсон зэргээс шалтгаалсан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр үүссэн хэмнэлтээр өөр худалдан авалт хийгээгүй байна.

БҮЛЭГЗ. ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ, ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

В.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.

3.1.1. Төрийн байгууллагын хяналт хангалттай байна.

“Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ болон “Эрдэнэт-УС ДТС” ОНӨХК-ийн үйл ажиллагааны чиг үүргээс хамаарч аймгийн МХГ-аас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хэрэгжүүлжээ.

Хүснэгт № 10 Үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналтын зөрчлийн тоо

№	Он	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
1	2019 он	Албан шаардлага	42	1
		Зөвлөмж	-	-
2	2020 он	Албан шаардлага	32	1

		Зөвлөмж	-	2
3	2021 он	Албан шаардлага	40	1
		Зөвлөмж	-	-
4	Нийт	Албан шаардлага	114	3
		Зөвлөмж	-	2

“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-нд Эрчим хүчний зохицуулах хорооноос жил бүр тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын биелэлтийг дүгнэж, шинэчлэн тогтоодог байна.

Хүснэгт № 11 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын биелэлтийг дүгнэсэн байдал

№	Тусгай зөвшөөрлийн шаардлага	2019 он	2020 он	2021 он
1	Цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл	Сайн	Дунд	Хангалттай сайн
2	Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл	Дунд	Сайн	Сайн

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу айл өрхийн үзүүлсэн цахилгаан дулааны хөнгөлөлттэй холбоотой хөнгөлөлтөд эрчим хүчний зохицуулах хорооноос хяналт хэрэгжүүлж, зөрүүтэй тооцож хөнгөлөлт чөлөөлөлт олгосон 12 аж ахуй нэгжид 2.9 сая төгрөгийн дулаан, цахилгааны нөхөн төлөлт тооцон, нэхэмжилж, төлбөрийг барагдуулсан байна.

Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр арилгаж, биелэлтийг хяналт хэрэгжүүлсэн байгууллагад хүргүүлж ажилласан байна.

3.1.2. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.


Санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитын газар, Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын алба, Татварын хэлтэс хөндлөнгийн хяналт шалгалтыг хийсэн байна. Хяналт шалгалтаар 2019-2021 онд нийт 210.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 2,682.0 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 5,897.4 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлжээ. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр залруулж, биелэлтийг хяналт хэрэгжүүлсэн байгууллагад хүргүүлж ажилласан байна.

Хүснэгт №12 Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /сая.төгрөг/

№	Он	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Эрдэнэт ус ОНӨХК	ХББЗА ОНӨАА ТҮГ	Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ	Нийт
1	2019 он	Акт	202.5	3.9	1.1	-	0.1	-	207.5
		Албан шаардлага	2.3	1.6	25.6	1.5	-	-	31.0
		Зөвлөмж	204.8	3.7	2.5	-	73.0	9.4	293.4

2	2020 он	Акт	-	1.2	-	-	-	-	1.2
		Албан шаардлага	2,246.8	0.8	-	31.6	20.0	-	2,299.2
		Зөвлөмж	5,388.0	69.0	19.5	14.9	8.2	3.6	5,503.2
3	2021 он	Акт	-	0.3	0.6	0.1	0.7	-	1.7
		Албан шаардлага	266.9	3.5	79.8	-	1.6	-	351.8
		Зөвлөмж	-	35.0	65.1	0.1	0.5	0.1	100.8
4	Нийт	Акт	202.5	5.4	1.7	0.1	0.8	-	210.5
		Албан шаардлага	2,516.0	5.9	105.4	33.1	21.6	-	2,682.0
		Зөвлөмж	5,592.8	107.7	87.1	15.0	81.7	13.1	5,897.4

Дүрслэл №1



Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг үзэхэд алдаа зөрчил 2021 онд буурсан байгаа нь хяналт шалгалт үр нөлөөтэйг илтгэж байна.

В.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хангалтгүй байна.

3.2.1. ТУЗ дэргэдээ аудитын хороо байгуулсан ч компанийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-ийн ТУЗ-ийн дэргэд аудитын хороо байгуулсан хэдий ч 2019-2021 онуудад огт хяналт хэрэгжүүлээгүй байна.

Харин “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ, “ХББЗА” ОНӨААТҮГ, “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ, “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ын ТУЗ нь Компанийн тухай хуулийн 81.1-д “Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно” гэж заасны дагуу дэргэдээ аудитын хороо байгуулаагүй байна.

Иймд Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

3.2.2. Дотоод хяналт хангалтгүй, үйл ажиллагааг нь сайжруулах шаардлагатай байна.

Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-ийн ТУЗ нь дотоод хяналт шалгалтын хэлтсийг 2019 онд 5 хүний бүрэлдэхүүнтэй, 2020 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй, 2021 онд гүйцэтгэх удирдлагын

дэргэд дотоод хяналт шалгалтын 1 ажилтантай байхаар бүтэц орон тоог баталжээ.

Дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг жил бүр гүйцэтгэх захирлаар төлөвлөгөөний дагуу удирдамж батлуулж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг холбогдох хэлтэст зөвлөмжөөр хүргүүлж ажилладаг байна. Дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг 2019 - 2021 онуудыг харьцуулахад 4 чиглэлээр 16 ажлыг жил бүр төлөвлөсөөр иржээ. Тухайн зөрчлүүд давтагдаж, өмнөх онтой харьцуулж өөрчлөлт гарсан эсэхийг тооцдоггүйгээс 2019 оны 5, 2020 оны 14, 2021 оны 9 зөвлөмжийн биелэлт бүрэн биелээгүй байна.

Хүснэгт №13 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил

№	Он	Хяналт шалгалтын хэлбэр	Хяналт шалгалтын тоо	Илэрсэн зөрчлийн дүн /сая төгрөг/	Төвлөрүүлэлт
1	2019 он	Төлөвлөгөөт	32		
		Төлөвлөгөөт бус	12	11.8	10.8
		Гэнэтийн шалгалт	-	-	-
2	2020 он	Төлөвлөгөөт	20	3.5	3.5
		Төлөвлөгөөт бус	5	4.0	3.9
		Гэнэтийн шалгалт	3	0.3	0.3
3	2021 он	Төлөвлөгөөт	14	-	-
		Төлөвлөгөөт бус	1	39.0	38.9
		Гэнэтийн шалгалт	1	11.8	11.8
4	Нийт	Төлөвлөгөөт	66	3.5	2.5
		Төлөвлөгөөт бус	18	54.8	53.8
		Гэнэтийн шалгалт	4	12.1	12.1

2019-2021 онд төлөвлөгөөт бус, гэнэтийн хяналт шалгалтаар 70.3 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, байгууллагад 69.3 сая төгрөгийг төвлөрүүлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлжээ.

Дотоод хяналт шалгалтын 1 ажилтантай байгаа нь хараат бус байдал хангагдахгүй, дотоод хяналт үр нөлөөгүй хэрэгжих үр дагавартай байна.

Дотоод хяналт шалгалтын ажилтан нь байгууллагад мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, ЗГ-ын тогтоол шийдвэрийн талаар сургалт зохион байгуулаагүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.5-д "хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан нь мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, ЗГ-аас гарсан тогтоолын дагуу сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

"ХББЗА" ОНӨААТҮГ, "Эрдэнэт ШУТП" ОНӨААТҮГ, "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ нь Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг баталж, дотоод хяналтын нэгжийг томилсон боловч журмын дагуу төлөвлөгөө боловсруулдаггүй, хяналт шалгалт хийсэн талаар баримтаар бүрэн нотлогдохгүй, хангалтгүй байна.

"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨААТҮГ, "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ нь 5-7 албан хаагчтай тул дотоод хяналтын нэгжгүй

байна. Иймд ОНӨААТҮГ-ууд нь дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

В.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангасан ч төрийн байгууллагын мэдээллийн уялдаа хангалтгүй байна.

3.3.1. Төрийн байгууллагын мэдээллийн уялдаа хангалтгүй байна.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдүүд нь санхүүгийн тайланг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлж, өмчийн ашиглалт хамгаалалт, хөрөнгийн тооллогыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлдэг байна.

“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, Санхүүгийн зохицуулах хороо, аймгийн Статистикийн хэлтэст мэдээ, тайлан, судалгааг сар, улирал, хагас бүтэн жилээр гаргаж хүргүүлдэг байна.

“Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг Орхон аймагт шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, сургалт үйлдвэрлэл, инновацын үйл ажиллагаа эрхлэх, байгууллагын дүрэмд орон нутгийн хэмжээнд хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох судалгаа, бодлогын баримт бичиг боловсруулах ажилд хамтран оролцох, зөвлөх, шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, сургалт, инновацын үйл ажиллагаа эрхлэх, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага мөн гэж заасан. Гэтэл тус ОНӨААТҮГ-ыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/686 захирамжаар нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлж барьцаагүй, хүүгүй зээл, 2020 онд А/293 захирамжаар гарааны бизнесийг дэмжих зээл, 2021 онд А/402 захирамжаар иргэдэд зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа нь ОНӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй нь байгууллагын дүрэмд нийцэхгүй байна.

ХББЗА ОНӨААТҮГ нь улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг аймгийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах, барилга байгууламжид үе шатны хяналт тавьж ашиглалтад оруулах, зураг төсөл зохиох гэж заасан байна. Харин Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “дараах барилгын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ”, 19.1.1-д “энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” гэж заасан тусгай зөвшөөрөлгүй байтал орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээний зураг төслийг боловсруулсаар байна.

Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-н 3.3-д “аймгийн Өмчийн харилцааны газар нь орон нутгийн өмчийн төлөөлөгч, ТУЗ-н гишүүдийг томилуулах, өөрчлөх төлөөр аймгийн Засаг даргын саналыг боловсруулж аймгийн ИТХТ-ээр шийдвэрлүүлэх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, туслах ажлыг хариуцна”, 5.4-д “аймгийн Өмчийн харилцааны газар орон нутгийн өмчит ба орон

нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсвийн төслийг хянан нэгтгэж, санал дүгнэлтийн хамт 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлнэ” гэж заасан байна. Гэтэл ОНӨГ нь журмын дагуу ТУЗ-д хяналт хэрэгжүүлээгүй, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсвийн төслийг хянаж нэгтгээгүй зэрэг нь журмын хэрэгжилт хангалтгүй, төрийн байгууллагын уялдааг сайжруулахаар байгааг илтгэж байна.

ОНӨГ нь орон нутгийн өмчит болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг хянаж, аймгийн ИТХ-ын баталсан тогтоол, журмыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

3.3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл ил тод нээлттэй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу байгууллагын мэдээллийг shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

Мөн “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК нь erdenet-us.gov.mn, “ХББЗА” ОНӨААТҮГ нь erdenetbarilga.mn, “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ нь erdenetpark.mn өөрийн вэб хуудсыг хөгжүүлж, байгууллагын ерөнхий мэдээлэл, тендерийн мэдээлэл, санхүүгийн мэдээллийг байршуулдаг байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч орон нутгийн оролцоотой хуулийн этгээдүүдэд түүний хэрэгжилт дутмаг байна.
- Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт үр дүнгүй байна.
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, баталдаггүй, аймгийн ИТХ-аас баталсан журам бүрэн хэрэгжээгүй байна.
- Орон нутгийн өмчийн оролцоотой 6 байгууллагын 5 байгууллагын орлого зорилтот түвшиндээ хүрээгүй тасарсан байна.
- Орон нутгийн өмчит байгууллагууд санхүүгийн үр ашгийн тооцоо шинжилгээ хийж, үр нөлөөг дүгнэдэггүй, их хэмжээний хэлцлийн үр дүнгээр орох ногдол ашиг бүрэн төвлөрөөгүй.
- Контрактын гэрээнд бусад нэмэгдэл цалинг тодорхой тусгадаггүй, ОНӨААТҮГ-ууд удирдлагын зардлыг төлөвлөдөггүй байна.
- Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тавих хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.
- ОНӨХК-ны дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, ОНӨААТҮГ-н дотоод

хяналт хангалтгүй байна.

- Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангасан ч төрийн байгууллагын мэдээллийн уялдаа хангалтгүй байна.

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 27.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-д:

- Аймгийн ИТХ-ын 2013 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”, 2016 онд 02 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд хяналт тавих.
- ТУЗ-ын гишүүдийг хууль эрх зүйн шаардлагад нийцсэн гишүүнээр томилж, хариуцлагыг дээшлүүлж ажиллах,
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дүрэмд заасан үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг эрхлүүлэх,
- Орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үйл ажиллагааг ижил төстэй төсвийн байгууллагад нэгтгэх, оновчтой зохион байгуулалт хийж төсвийн үр ашигтай байдлыг хангаж ажиллах.

Аймгийн засаг дарга С.Батжаргалд:

- Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн контрактын гэрээнд захирлын үндсэн цалин болон бусад нэмэгдлийг тодорхой тусгах,
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дүрэмд заасан үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг эрхлүүлэх,

“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-н ТУЗ-д

- ТУЗ-н дэргэдэх аудитын хороо Компанийн тухай хуулийн 81.4 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ОНӨААТҮГ болон ОНӨХК-д

- Санхүүгийн үр ашгийн шинжилгээг хийж, үр дүнг нэгтгэн хэлэлцэж, үйл ажиллагааны үр ашгийг тооцож, арга хэмжээ авч ажиллах.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг


Орон нутгийн өмчийн газарт:

- Орон нутгийн өмчит болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг хянаж, аймгийн ИТХ-аар баталсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Т.БОЛОРМАА
Б.БЯМБАТОГТОХ
О.ХЭРЛЭНЗАЯА

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Уртбулаг баг, Ханддоржийн гудамж,
Утас: 70350493, Факс: 70352631

Цахим шуудан: orkhonith33@gmail.com

2022.07.06 № 01/165
танай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллах бөгөөд тайлангийн төсөлд өөр саналгүй болно.

ДАРГА

Г.МӨНХБАТ



C:\My documents\root\A5

079180877

ХАВСРАЛТУУД: Хавсралт 1. Судалгаа

№	Санхүүгийн үзүүлэлт	Эрдэнэт ус ОНӨХК			ХББЗА ОНӨААТҮГ			Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ			Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ			Их шүтээн ОНӨААТҮГ			Цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ		
		2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
1	Борлуулалтын орлого	16,420.7	17,995.9	20,725.1	403.47	458.96	474.84	695.29	575.99	127.13	39.1	28.8	49.1	1.91	0.076				
2	ББӨ	10,325.0	11,082.6	12,714.4				290.01	90.83	50.28									
3	Нийт ашиг алдагдал	6,095.7	6,913.3	8,010.8	403.5	459.0	474.8	405.3	485.16	76.9	39.1	28.8	49.1	1.9	0.1	-	-	-	-
4	Бусад орлого	123.7	166.3	98.7	11.28	4.3	3.77	1.49	0.04	37.58	31.2	21.4	18.1	68.14	55.95	64.72	9.49	78.26	168.13
5	ногдол ашгийн орлого									12.50				0.002					
6	Борлуулалт маркетингийн зардал						447.14	16.25	16.29	9.99									
7	Ерөнхий удирдлагын зардал	7,109.9	7,772.1	8,106.9	386.9	418.57	29.086	259.96	227.53	183.67	70.1	70.4	85.2	142.75	138.84	153.43	9.24	65.29	122.78
8	Санхүүгийн зардал								4.90	1.80	2.7	2.3	2.3				0.086	8.22	38.92
9	Бусад зардал				8.03		0.91	18.25	37.49	33.87							2.39	155.28	237.22
10	Зардлын дүн	7,109.9	7,772.1	8,106.9	394.9	418.6	477.1	294.5	286.21	229.3	72.8	72.7	87.5	142.8	138.8	153.4	11.7	228.8	398.9
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	(2.0)	(24.6)	(1.29)		(3.49)		(30.15)							(7.63)				(37.08)
12	Бусад ашиг алдагдал	309.1	186.3	1.10												(0.2)			
13	Олз гарзын дүн	307.1	161.7	(0.19)	-	(3.5)	-	(30.2)	-	-	-	-	-	-	(7.6)	(0.2)	-	-	(37.1)
14	Татварын өмнөх ашиг алдагдал	(583.4)	(530.7)	2.36	19.8	41.20	1.47	82.2	199.00	(102.4)	(2.5)	(22.5)	(20.3)	(72.7)	(90.4)	(88.9)	(2.2)	(150.5)	(267.9)
15	Орлогын албан татварын зардал	2.5	1.4	0.78	1.7	6.77	0.24	8.21	19.90										
16	ТДАшиг алдагдал	(585.9)	(532.1)	1.58	18.1	34.43	1.23	74.0	179.10	(102.4)	(2.5)	(22.5)	(20.3)	(72.7)	(90.4)	(88.9)	(2.2)	(150.5)	(267.9)